

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулахаас сэргийлэх зорилгоор тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх, эд зүйл болон төрийн нийтийн зориулалттай өмч эзэмших, ашиглах эрх олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Зөвшөөрлийн хууль тогтоомж

2.1.Зөвшөөрлийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, Улсын бүртгэлийн ерөнхий хууль<sup>3</sup>, Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хууль<sup>4</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."зөвшөөрөл" гэж эрх бүхий этгээдээс тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх, эд зүйл болон төрийн нийтийн зориулалттай өмч эзэмших, ашиглах эрхийг хуульд заасны дагуу хүн, хуулийн этгээдэд олгохыг;

3.1.2."зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд" \цаашид "эрх бүхий этгээд" гэх\ гэж хуулиар зөвшөөрөл олгох бүрэн эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан, эсхүл зөвшөөрөл олгох эрхийг шилжүүлэн авсан этгээдийг.

##### 4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Улсын бүртгэлийн ерөнхий хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Улсын бүртгэлийн ерөнхий хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны дугаарт нийтлэгдсэн.

4.1.Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуульд заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүйд тооцох, цуцлах, тэдгээрийг бүртгэх болон зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлагыг энэхүү хуулиар тогтооно.

4.2.Зөвшөөрлийн ангилал, төрлийн онцлогоос хамаарч түүнийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүйд тооцох, цуцлах тусгай журам болон зөвшөөрөл эзэмшигчид тавигдах тусгай шаардлагыг энэ хуульд нийцүүлэн холбогдох хуулиар тогтоож болно.

4.3.Доор дурдсан харилцааг энэ хуулиар зохицуулахгүй:

4.3.1.Монгол Улсын иргэнд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох;

4.3.2.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд цагаачлан оршин суух зөвшөөрөл олгох, гадаадын иргэнд Монгол Улсын хилээр нэвтрүүлэх эрх олгох буюу Монгол Улсын виз олгох, Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг олгох, олгосон виз, зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

4.3.3.сүм хийд, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллага байгуулах;

4.3.4.патент, зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн болон газар зүйн заалт, барааны тэмдэг эзэмшигчийн эрх олгох.

4.4. Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуульд зааснаас бусад тодорхой нэг тохиолдлыг зохицуулах зорилгоор хэрэгжүүлэх нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаанд зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

## **5 дугаар зүйл.Нийтлэг зарчим**

5.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараахь нийтлэг зарчмыг баримтална:

5.1.1.үндэсний аюулгүй байдал, улс орны болон нийтийн эрх ашиг, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах;

5.1.2.үл ялгаварлах, тэгш боломж олгох, ил тод, нээлттэй байх;

5.1.3.шуурхай, хариуцлагатай байх;

5.1.4.эдийн засгийн өсөлт, шударга өрсөлдөөнийг дэмжих;

5.1.5.аж ахуй эрхлэх таатай орчинг бүрдүүлэх;

5.1.6.олон улсын жишиг стандарт, шаардлагыг нэвтрүүлэхийг дэмжих.

5.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт хүн, хуулийн этгээд нь хуулиар хориглосон болон Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуульд зааснаас бусад үйл ажиллагааг хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно.

5.3.Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүний амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, шударга бус өрсөлдөөнийг хориглох зорилгоор тодорхой төрлийн зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг хязгаарлах, эсхүл нэг жилд олгох зөвшөөрлийн тоо хэмжээг тогтоож болно.

5.4.Энэ хуулийн 5.3-т заасан үндэслэлээр тодорхой төрлийн зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагаанд тогтоох хязгаарлалтыг Улсын Их Хурал, нэг жилд олгох зөвшөөрлийн тоо хэмжээг Засгийн газар тогтооно.

## **6 дугаар зүйл.Хориглох үйл ажиллагаа**

6.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

6.1.1.хар тамхи, хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах үйлчилгээтэй ургамал тариалах, тээвэрлэх, зуучлах худалдах;

6.1.2.хар тамхи, хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн угтвар бодисыг агуулсан эм, бэлдмэлийг үйлдвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх, худалдах, үйлчлэх;

6.1.3.садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр сурталчлах, дэмжих;

6.1.4.хуульд өөрөөр заагаагүй бол казино, мөрийтэй болон бооцоот тоглоом, төлбөрт тааврын үйл ажиллагаа зохион байгуулах;

6.1.5.аяултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах, тээвэрлэх зорилгоор Монгол Улсад импортоор оруулах;

6.1.6.аяултай хог хаягдлыг Монгол Улсын хил дамжуулан тээвэрлэх;

6.1.7.үй олноор хөнөөх зэвсэг, технологийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх;

6.1.8.олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа.

6.2.Эрх бүхий этгээдээс олгох зөвшөөрлийн төрлийг хуулиар тогтооно. Хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрлийг шинээр бий болгох, олгохыг хориглоно.

6.3.Хуульд заасныг зөрчиж зөвшөөрөл олгосны улмаас төр болон бусад этгээдэд хохирол учирсан бол уг хохирлыг зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд хариуцна.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗӨВШӨӨРӨЛ, ТҮҮНИЙ АНГИЛАЛ**

### **7 дугаар зүйл.Зөвшөөрөл**

7.1.Эрх бүхий этгээд нь зөвшөөрлийг батлагдсан маягт бүхий баримт бичгээр олгоно.

7.2.Зөвшөөрөлд дараахь зүйлийг тусгана:

7.2.1.зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээдийн нэр, хаяг;

7.2.2.зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг;

7.2.3.зөвшөөрлийн нэр төрөл, ангилал, түүний код;

7.2.4.зөвшөөрлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төрөл, хэрэгжүүлэх нутаг дэвсгэр;

7.2.5.зөвшөөрлийн дугаар, олгосон огноо;

7.2.6.зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа буюу дуусах огноо;

7.2.7.эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга \тэмдэг\.

7.3.Зөвшөөрлийн маягтыг Засгийн газар батална.

7.4.Зөвшөөрлийн баримт бичгийг бусдад шилжүүлэх, барьцаалах, санаатайгаар гэмтээх, устгахыг хориглоно.

## **8 дугаар зүйл.Зөвшөөрлийн ангилал**

8.1.Зөвшөөрөл нь дараахь ангилалтай байна:

8.1.1.онцгой;

8.1.2.тусгай;

8.1.3.энгийн.

8.2.Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, олон улсын хамтын ажиллагаа, энх тайванд хор уршиг учруулж болзошгүй эрсдэлтэй үйл ажиллагаа эрхлэх, эсхүл энэ хэсэгт заасан шинж бүхий өмчийг эзэмших, ашиглах эрхийг онцгой зөвшөөрлөөр олгоно.

8.3.Нийтийн эрх ашиг, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй эрсдэлтэй үйл ажиллагаа эрхлэх, эсхүл энэ хэсэгт заасан шинж бүхий өмчийг эзэмших, ашиглах эрхийг тусгай зөвшөөрлөөр олгоно.

8.4.Мэргэжлийн үйлчилгээ, үйл ажиллагаа болон эрсдлийн түвшин бага хэдий ч нийтийн ашиг сонирхлын үүднээс хязгаарлалт тогтоох шаардлага бүхий үйл ажиллагаа эрхлэх, энэ хэсэгт заасан шинж бүхий өмчийг эзэмших, ашиглах эрхийг энгийн зөвшөөрлөөр олгоно.

8.5.Энэ хуулийн 8.1-д заасан ангилалд хамаарах зөвшөөрлийн төрлийг Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулиар тогтооно.

8.6.Онцгой зөвшөөрлийг хувь хүнд олгохыг хориглоно.

8.7.Хувь хүнд олгохыг хориглох тусгай болон энгийн зөвшөөрлийн төрлийг холбогдох хуулиар тогтооно.

## **9 дүгээр зүйл.Зөвшөөрлийн төрлийн код**

9.1.Зөвшөөрлийн нэгдсэн бүртгэл хөтлөх, статистик мэдээг эрхлэн гаргах, лавлагаа өгөх, зөвшөөрлийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах зорилгоор зөвшөөрлийн нэр төрлийн кодыг хэрэглэнэ.

9.2.Зөвшөөрлийн нэр төрлийн кодыг тогтооход зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны төрөл, барааны ангиллын жагсаалт болон үндэсний кодыг ашиглана.

9.3.Зөвшөөрлийн нэр төрлийн кодыг хуулиар тогтооно.

## **10 дугаар зүйл.Зөвшөөрлийн хугацаа**

10.1.Зөвшөөрлийг доор дурьдсан хугацаагаар олгоно:

- 10.1.1.онцгой зөвшөөрлийг 5 жил хүртэл;
- 10.1.2.тусгай зөвшөөрлийг 10 жил хүртэл;
- 10.1.3.энгийн зөвшөөрлийг хугацаагүй.

10.2.Холбогдох хуулиар онцгой болон тусгай зөвшөөрөл олгох хугацааг үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашиг, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй эрсдэлтэй нөхцөлийг харгалзан энэ хуулийн 10.1.1, 10.1.2-т зааснаас богино хугацаагаар тогтоож болно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД**

### **11 дүгээр зүйл.Эрх бүхий этгээд**

11.1.Зөвшөөрөл олгох шийдвэрийг түүний ангиллаас хамааран дараахь эрх бүхий этгээд гаргана:

11.1.1.онцгой зөвшөөрлийг Засгийн газар, Монголбанк;

11.1.2.тусгай зөвшөөрлийг Засгийн газрын гишүүн, хуулиар зөвшөөрөл олгох бүрэн эрх олгогдсон байгууллагыг төлөөлөх албан тушаалтан, тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх олгосон албан тушаалтан, аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл хуулиар эрх шилжүүлэн авсан этгээд;

11.1.3.энгийн зөвшөөрлийг Засгийн газрын гишүүн, тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх олгосон албан тушаалтан, хуулиар зөвшөөрөл олгох бүрэн эрх олгогдсон байгууллагыг төлөөлөх албан тушаалтан;

11.2.Тусгай, энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана.

11.3.Энэ хуулийн 11.2-т заасан жагсаалтыг тухайн төрийн байгууллага нь цахим хуудсандаа байрлуулах болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлэх үүрэгтэй.

### **12 дугаар зүйл.Эрх бүхий этгээдийн бүрэн эрх**

12.1.Эрх бүхий этгээд нь дараахь эрхтэй:

12.1.1.хуульд заасан харьяаллын дагуу зөвшөөрлийг олгох, сунгах, цуцлах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох шийдвэр гаргах;

12.1.2.зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих;

12.1.3.зөвшөөрөл эзэмшигчээс мэдээ, тайлан гаргуулан авах;

12.1.4.хуулиар эрх олгосон бол захиргааны акт батлан мөрдүүлэх;

12.1.5.зөвшөөрлийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмж гаргах.

12.2.Эрх бүхий этгээд нь дараахь үүрэг хүлээнэ:

12.2.1.хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрхээ хэрэгжүүлэх;

12.2.2.мэдээллийг энэ хуулийн 25-д заасан нэгдсэн санд төвлөрүүлэх, иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэх;

12.2.3.иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө, мэдээллээр хангах.

### **13 дугаар зүйл.Зөвшөөрөл олгох эрх шилжүүлэх**

13.1.Онцгой зөвшөөрөл олгох эрхийг өөр этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

13.2.Хуульд тусгайлан заасан тохиолдолд эрх бүхий этгээд нь тусгай болон энгийн зөвшөөрөл олгох эрхээ төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан, эсхүл Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн 7.1.3, 7.1.7-д заасан хуулийн этгээдэд шилжүүлж болно.

13.3.Эрх шилжүүлэн авсан этгээд нь энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан эрхийг эдэлж, үүргийг хэрэгжүүлнэ.

13.4.Энэ хуулийн 13.2-т заасан эрх шилжлүүлэх журмыг Засгийн газар тогтооно.

13.5.Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох эрхээ бусдад шилжүүлсэн бол шийдвэрийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, энэ тухай нийтэд мэдээлэх арга хэмжээ авна.

13.6.Зөвшөөрөл олгох эрхийг хууль бусаар шилжүүлсний улмаас бусдад учирсан хохирлыг тухайн эрх шилжүүлсэн этгээд хариуцна.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ**

### **14 дүгээр зүйл.Зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

14.1.Зөвшөөрөл эзэмшигч нь дараахь нийтлэг эрх эдэлнэ:

14.1.1.зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа эрхлэх, өмчийг зохих журмын дагуу эзэмших, ашиглах;

14.1.2.зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргах, зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, цуцлахтай холбоотой мэдээлэл, лавлагаа, тайлбар авах;

14.1.3.эрх бүхий этгээдийн үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой гомдол гаргах;

14.1.4.эрх бүхий этгээдээс зөвшөөрлийг зохих журмын дагуу хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөгөө, мэдээлэл хүсэх;

14.1.5.хуульд заасан бусад.

14.2.Зөвшөөрөл эзэмшигч нь дараахь нийтлэг үүрэгтэй:

14.2.1.тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах, зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээдийг холбогдох мэдээлэл, лавлагаагаар тухай бүр хангах;

14.2.2.хуулиар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах;

14.2.3.хуулиар хориглосон, эсхүл хязгаарласан тохиолдолд зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад зааснаас бусад үйл ажиллагаа давхардуулан эрхлэхгүй байх;

14.2.4.зөвшөөрөл авсан даруй харьяалах татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх;

14.2.5.Монгол улсын хууль тогтоомж, үндэсний болон олон улсын стандартыг хангаж ажиллах;

14.2.6.хуульд заасан бусад.

14.3.Үйл ажиллагааны онцлогоос хамаарч зөвшөөрөл эзэмшигчид нэмэлт эрх, үүргийг холбогдох хуулиар тогтоож болно.

14.4.Зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг нь тухайн зөвшөөрлийг олгосон өдрөөс эхлэн үүснэ.

14.5.Зөвшөөрлийг худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

### **15 дугаар зүйл.Зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага**

15.1.Зөвшөөрөл эзэмшигч хүн, хуулийн этгээд нь дараахь нийтлэг шаардлагыг хангасан байна:

15.1.1.эрх зүйн бүрэн чадамжтай;  
15.1.2.зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, эсхүл Монгол Улсад байнга оршин суудаг байх;

15.1.3.татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх;  
15.1.4.татварын өргүй байх.

15.2.Зөвшөөрөл эзэмшигчид тавигдах тусгай нөхцөл, шаардлагыг холбогдох хуулиар тогтооно.

#### **16 дугаар зүйл.Зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах**

16.1.Хуульд заасан тохиолдолд эрх бүхий этгээд нь зөвшөөрөл эзэмшигчид тавигдах тусгай шаардлага, нөхцөлийг хэрэгжүүлэх зорилгоор зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж болно.

16.2.Гэрээ байгуулах, дүгнэх журмыг холбогдох хуулиар зохицуулна.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГАХ**

#### **17 дугаар зүйл.Зөвшөөрөл авах тухай хүсэлт гаргах**

17.1.Хүн, хуулийн этгээд нь зөвшөөрөл авах хүсэлтийг холбогдох эрх бүхий этгээдэд гаргана. Хүсэлтийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргаж болно.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан хүсэлт нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

17.3.Хүсэлт гаргагч нь хүсэлтэндээ зөвшөөрлийн нэр төрөл, түүнд холбогдох үйл ажиллагаа эрхлэх, нийтийн өмч, эрхийг эзэмших, ашиглах зорилго, үндэслэлийг тусгаж, дараахь баримт бичгийг хавсаргасан байна:

17.3.1.хуульд заасан нийтлэг болон тусгай нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичиг;

17.3.2.зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар, түүнтэй адилтгах бусад баримт бичиг;

17.3.3.татварын өр төлбөргүй болохыг гэрчилсэн баримт;  
17.3.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

17.4.Эрх бүхий байгууллага хүсэлтийг хүлээн авахдаа тусгай тэмдэглэл үйлдэх бөгөөд хүсэлт гаргагчийн талаарх мэдээлэл, хаяг, хүсэлт гаргасан хэлбэр,



огноо, цаг минут, хүсэлтийн товч агуулга, хавсаргасан баримт бичгийн жагсаалтыг тусгана.

17.5.Эрх бүхий байгууллага хүсэлт нь энэ хуулийн 17.2, 17.3-т заасан шаардлагыг хангасан эсэхийг ажлын 3 өдрийн дотор хянаж, нэмэлт баримт бичиг шаардлагатай бол хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

17.6.Хүсэлт гаргагч нь энэ хуулийн 17.3-т заасан баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх, эрх бүхий этгээдийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

### **18 дугаар зүйл.Хүсэлтийг шийдвэрлэх журам**

18.1.Эрх бүхий этгээд нь хүсэлтийг дараахь хугацаанд хянан шийдвэрлэнэ:

18.1.1.онцгой зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор;

18.1.2.тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 14 өдрийн дотор;

18.1.3.энгийн зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор.

18.2.Хүсэлтийг шийдвэрлэхтэй холбоотой нэмэлт ажиллагаа хийх шаардлагатай бол хугацааг зөвшөөрлийн ангилалаас хамаарч энэ хуулийн 18.1-д заасан хугацаагаар нэг удаа сунгаж болно.

18.3.Эрх бүхий этгээд онцгой болон тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх зорилгоор нягтлан шалгах, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг томилж болно.

18.4.Эрх бүхий этгээд нь хүсэлтийг хянаад дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

18.4.1.зөвшөөрөл олгох;

18.4.2.зөвшөөрөл олгохоос татгалзах.

18.5.Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгохоос татгалзсан бол шийдвэрээ хүсэлт гаргагчид шийдвэр гаргаснаас хойш ажлын 3 өдрийн дотор бичгээр хүргүүлнэ. Шийдвэрт татгалзсан шалтгаан, түүний үндэслэлийг тодорхой тусгасан байна.

### **19 дүгээр зүйл.Зөвшөөрөл олгох**

19.1.Эрх бүхий этгээд хүсэлтийг хянаад энэ хуулийн 15 дугаар зүйл болон холбогдох бусад хуулиар тогтоосон шаардлагыг хангасан гэж үзвэл зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргана.

19.2.Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан бол шийдвэрийг хүсэлт гаргагчид даруй мэдэгдэж, зөвшөөрлийн баримт бичгийг ажлын 5 өдрийн дотор олгоно.

19.3.Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгосон шийдвэрийг хуульд заасан журмын дагуу Зөвшөөрлийн бүртгэлийн нэгдсэн санд хүргүүлж, бүртгүүлнэ.

19.4.Энгийн зөвшөөрөл хүссэн хүсэлтийн хариуг энэ хуульд заасан хугацаанд өгөөгүй бол зөвшөөрөл олгосонд тооцно.

19.5.Хуульд өөрөөр заагаагүй бол тодорхой төрлийн зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг хялбаршуулсан, эсхүл сонгон шалгаруулалтын журмаар явуулж болно.

19.6.Энэ хуулийн 19.5-д заасан журмыг Засгийн газар батална.

19.7.Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуульд заасан зөвшөөрлийн нэр төрлийг задлах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэхийг хориглоно.

19.8.Хуульд заасан бол зөвшөөрлийг нэг хүн, эсхүл нэг хуулийн этгээдэд олгоно.

19.9.Хуульд заасан бол зарим төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг зөвхөн холбогдох бусад төрлийн зөвшөөрөл эзэмшигчид олгоно.

## **20 дугаар зүйл.Зөвшөөрлийн хугацааг сунгах**

20.1.Зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн хугацаа дуусахаас нэг сараас доошгүй хугацааны өмнө түүнийг сунгуулах тухай хүсэлтийг эрх бүхий этгээдэд гаргана.

20.2.Эрх бүхий этгээд энэ хуулийн 20.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

20.3.Зөвшөөрлийг сунгах хүсэлттэй холбогдуулан нягтлан шалгуулах, мэргэжлийн байгууллагаар магадлан шинжлүүлэх шаардлагатай бол энэ хуулийн 20.2-т заасан хугацааг ажлын 10 хүртэл өдрөөр сунгаж болно.

20.4.Зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 15-д заасныг зөрчөөгүй, хуульд заасан нөхцөл, шаардлага хангаж байгаа бол түүний хүсэлтийн дагуу зөвшөөрлийн хугацааг сунгаж болно.

20.5.Зөвшөөрлийн хугацааг анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгана.

20.6.Зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн бол зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан шийдвэрийг гаргах бөгөөд шийдвэрт татгалзсан шалтгаан, түүний үндэслэлийг тодорхой тусгасан байна.

20.7.Эрх бүхий этгээд зөвшөөрлийн хугацааг сунгасан, эсхүл сунгахаас татгалзсан шийдвэрийг бичгээр гаргаж, ажлын 3 өдрийн дотор хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

20.8.Хүсэлт гаргагч энэ хуулийн 20.7-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн эрх бүхий этгээдийн дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ЦУЦЛАХ**

### **21 дүгээр зүйл.Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх**

21.1.Эрх бүхий этгээд зөвшөөрлийг дараахь тохиолдолд гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно:

21.1.1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

21.1.2.зөвшөөрөл эзэмшигч хуульд заасан нийтлэг болон тусгай нөхцөл, шаардлагыг хангахгүйд хүрч болзошгүй нөхцөл байдал үүссэн;

21.1.3.мэдээ, тайланг хуулиар тогтоосон хугацаанд, эсхүл хуульд заасан шаардлагын дагуу гаргаж өгөөгүй;

21.1.4.зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн дотор үйл ажиллагаа эрхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.

21.2.Эрх бүхий этгээд энэ хуулийн 21.1-д заасан үндэслэл байгаа тухай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдэл хүргүүлснээс хойш 30 хоногийн дотор түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

21.3.Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл, нөхцөл арилсан тохиолдолд зөвшөөрлийг сэргээнэ.

### **22 дугаар зүйл.Зөвшөөрлийг хүчингүйд тооцох**

22.1.Эрх бүхий этгээд дараахь үндэслэлээр зөвшөөрлийг хүчингүйд тооцно:

22.1.1.зөвшөөрөл эзэмшигч эрх зүйн чадвар, чадамжгүй байсан нь илэрсэн;

22.1.2.зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

22.1.3.зөвшөөрлийг хууль бус бусад үндэслэлээр олгосон.

22.2.Эрх бүхий этгээд энэ хуулийн 22.1-д заасан үндэслэл байгааг илрүүлсэн бол зөвшөөрлийг хүчингүйд тооцох шийдвэрийг гаргаж, зөвшөөрөл эзэмшигчид даруй мэдэгдэнэ.

22.3.Эрх бүхий этгээд энэ хуулийн 22.2-т заасан шийдвэрийг хуульд заасан журмаар улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлж, бүртгүүлнэ.

22.4.Зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийг хүчингүйд тооцсон шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн дагуу гомдол гаргах эрхтэй.

22.5.Эрх бүхий этгээд зөвшөөрлийг хүчингүйд тооцсон тохиолдолд тухайн этгээдээс 6 сарын дотор хүчингүйд тооцсон болсон шийдвэрт заагдсан зөвшөөрөл хүссэн өргөдлийг дахин хүлээж авахгүй.

### **23 дугаар зүйл.Зөвшөөрлийг цуцлах**

23.1.Зөвшөөрлийг дараахь үндэслэлээр цуцална:

23.1.1.зөвшөөрөл эзэмшигч хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

23.1.2.зөвшөөрөл эзэмшигч иргэн нь нас барсан, эрх зүйн чадамжгүй болсон;

23.1.3.зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан, өөрчлөн байгуулагдсан бол;

23.1.4.зөвшөөрөл эзэмшигч хууль болон гэрээнд заасан үүргээ ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

23.1.5.нийтийн эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлсэн, их хэмжээний хохирол учруулсан болох нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;

23.1.6.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээх хүсэлтийг эрх бүхий байгууллагад ирүүлээгүй;

23.1.7.зөвшөөрлийн хугацаа дууссан боловч сунгуулах хүсэлтийг хуульд заасан хугацаанд гаргаагүй;

23.1.8.зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлөө цуцлуулах хүсэлт гаргасан бол.

23.2.Зөвшөөрлийг цуцлах шийдвэр гаргахад энэ хуулийн 22.2, 22.3-т заасныг нэгэн адил мөрдөнө.

### **24 дүгээр зүйл.Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүйд тооцсон, цуцалсны үр дагавар**

24.1.Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд уг зөвшөөрлийн дагуу явуулах үйл ажиллагаа түдгэлзэх бөгөөд бусадтай байгуулсан холбогдох гэрээний үйлчлэлийг түр зогсоож болно.

24.2.Зөвшөөрлийг хүчингүйд тооцсон нь тухайн зөвшөөрөл эзэмшигч этгээдээс зөвшөөрлийн дагуу эрхлэх үйл ажиллагаатай холбогдуулан бусадтай байгуулсан гэрээг цуцлах үндэслэл болно.

24.3.Зөвшөөрлийг цуцалсан, хүчингүйд тооцсоны улмаас төр болон бусдад учруулсан хохирлыг зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд хариуцна.

24.4.Зөвшөөрлийг хүчингүйд тооцсон, цуцалсан бол зөвшөөрөл эзэмшигчийн тодорхой үйл ажиллагаа эрхлэх болон уг зөвшөөрөлтэй холбогдол бүхий бусад үйл ажиллагаанд олгосон зөвшөөрөл мөн дуусгавар болно.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ ЗӨВШӨӨРЛИЙН БҮРТГЭЛ, ХЯНАЛТ**

### **25 дугаар зүйл.Зөвшөөрлийн бүртгэлийн нэгдсэн сан**

25.1.Зөвшөөрлийн бүртгэлийн нэгдсэн санд зөвшөөрөл эзэмшигч болон олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүйд тооцсон, цуцалсан зөвшөөрлийн талаарх мэдээллийг эрх бүхий этгээд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

25.2.Зөвшөөрлийн бүртгэлийн сангийн мэдээллээр олон нийт, байгууллага, иргэдийг хангана.

25.3.Тусгай ба энгийн зөвшөөрлийн мэдээлэл нийтэд нээлттэй, ил тод байна.

25.4.Онцгой зөвшөөрөл эзэмшигчтэй холбоотой мэдээлэл хуульд заасны дагуу тухайн этгээдийн нууцад хамаарахаар бол зөвшөөрөл эзэмшигч этгээдийн зөвшөөрлийн үндсэн дээр лавлагаа, мэдээлэл олгож болно.

25.5.Лавлагаа, мэдээллийг цахим хэлбэрээр олгож болно.

25.6.Зөвшөөрлийн нэгдсэн бүртгэлийг хөтлөх журмыг Засгийн газар батална.

25.7.Лавлагаа, мэдээллийг үнэ төлбөртэй олгох бөгөөд хэмжээг бодит өртөг, зардалтай нь уялдуулан зөвшөөрлийн нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн байгууллагын дарга тогтооно.

### **26 дугаар зүйл.Зөвшөөрлийн хяналтын зөвлөл**

26.1.Зөвшөөрлийн хяналтын зөвлөл \цаашид "Зөвлөл" гэх\ нь орон тооны бус бөгөөд холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 9 гишүүнтэй байна. Зөвлөлийн дарга нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байна.

26.2.Зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

26.2.1.зөвшөөрөл олгох, бүртгэх эрх бүхий этгээдийг нэгдсэн арга зүйн удирдлагаар хангах;

26.2.2.зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүйд тооцох, цуцлах үйл ажиллагаа, түүний үр нөлөөний талаар хяналт шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, санал, дүгнэлт гаргах;

26.2.3.Зөвшөөрлийн тухай болон Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлаар санал, дүгнэлт гаргах;

26.2.4. зөвшөөрлийн тооллогыг жил бүр явуулж, тодорхой төрлийн зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагаанд, эсхүл тухайн жилд олгох зөвшөөрлийн тоо хэмжээнд хязгаарлалт тогтоох асуудлаар дүгнэлт гаргах;

26.3.Зөвлөл нь хуулийн хэрэгжилт, зөвшөөрөл шинээр бий болгох, олгох үйл ажиллагааны талаар санал, зөвлөмж гаргуулахаар шинжээч, мэргэжилтнийг татан оролцуулж болно.

26.4.Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар гүйцэтгэнэ.

26.5.Зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх болон зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.

26.6.Зөвлөл нь шийдвэрээ тогтоол, шаардлага, даалгавар хэлбэрээр гаргана.

26.7.Зөвлөлийн шийдвэрийг холбогдох этгээд биелүүлэх үүрэгтэй.

26.8.Зөвлөл хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд холбогдох байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллана.

26.9.Зөвлөл нь зөвшөөрөл, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь энэ хуулийн зорилго, зарчим, нөхцөл, шаардлагад нийцэж байгаа эсэхэд энэ хуулийн 27.2-т заасан асуудлаар хяналт шинжилгээг гурван жил тутам хийнэ.

26.10.Зөвлөл нь тооллогын болон хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлтийг тухай бүр Засгийн газарт танилцуулна.

## **27 дугаар зүйл.Зөвшөөрлийн ангилал, нэр төрөлд өөрчлөлт оруулах тухай дүгнэлт гаргах**

27.1.Зөвлөл нь зөвшөөрлийн нэр төрөл, ангилалд өөрчлөлт оруулах, шинээр зөвшөөрлийн нэр төрөл бий болгох, хасах асуудлаар дүгнэлт гаргана.

27.2.Зөвлөлийн дүгнэлтэд дараахь асуудлыг тусгана:

27.2.1.Улсын Их Хуралд өргөн барьж байгаа хуулийн төсөл нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх;

27.2.2.зөвшөөрлийн нэр төрлийн зайлшгүй хэрэгцээ, бодлогод үндэслэсэн, эрсдэлийн түвшин, үнэлгээтэй уялдсан байдал;

27.2.3.эдийн засаг, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөлөл;

27.2.4.зөвшөөрлийн нэр төрөл, ангилалд оруулах өөрчлөлттэй холбогдуулан улсын төсвөөс болон иргэн, хуулийн этгээд, хэрэглэгчээс гарах зардал.

27.3.Зөвшөөрлийн нэр төрөл, ангилалд өөрчлөлт оруулах тухай дүгнэлтийг санал, зөвлөмжийн хамт Засгийн газарт хүргүүлнэ.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **28 дугаар зүйл.Гомдол шийдвэрлэх**

28.1.Эрх бүхий этгээдийн шийдвэртэй холбоотой гомдлыг түүний дээд шатны албан тушаалтанд, эсхүл шүүхэд гаргаж шийдвэрлүүлнэ.

### **29 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

29.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

29.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **30 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

30.1.Энэ хуулийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

## ЗӨВШӨӨРЛИЙН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын нутаг дэвсгэрт доор дурдсан үйл ажиллагаа эрхлэх, эд зүйл болон нийтийн зориулалттай өмч эзэмших, ашиглахад эрх бүхий этгээд зөвшөөрөл олгоно:

№	Код	Зөвшөөрлийн нэр төрөл	Зөвшөөрлийн ангилал	Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
Нэг. Байгаль орчны чиглэлээр				
1.	1-0-01	Аюултай хог хаягдлыг цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, хадгалах, экспортлох	Онцгой	Засгийн газар
2.	1-Т-02	Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
3.	1-Т-03	Ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйл, ойн дагалт баялгийг импортлох, нэн ховор, ховор ургамлыг экспортлох	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
4.	1-Т-04	Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
5.	1-Т-05	Байгалийн ургамал, ойн дагалт баялаг, тэдгээрийн гаралтай түүхий эдийг бэлтгэх	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
6.	1-Т-06	Газрын доорх болон гадаргын усны эх үүсвэрийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан, Аймаг нийслэлийн Засаг дарга



7.	1-T-07	Усны мэргэжлийн байгууллагын эрх авах	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
8.	1-T-08	Озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнтэй харьцах	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
9.	1-T-09	Озон задалдаг бодис ашиглах	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
10.	1-T-10	Озон задалдаг бодис худалдах	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
11.	1-T-11	Химийн хорт болон аюултай бодис ашиглах	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
12.	1-T-12	Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
13.	1-T-13	Химийн хорт болон аюултай бодис худалдах	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
14.	1-T-14	Химийн хорт болон аюултай бодис экспортлох	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
15.	1-T-15	Химийн хорт болон аюултай бодис хил дамжуулан тээвэрлэх	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
16.	1-T-16	Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
17.	1-T-17	Химийн хорт болон аюултай бодис устгах	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
18.	1-T-18	Нэн ховор, ховор амьтныг агнах, барих	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
19.	1-T-19	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
20.	1-T-20	Хаягдал ус хаях, зайлуулах	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
21.	1-T-21	Агнуурын амьтныг ахуйн зориулалтаар агнах, барих	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
22.	1-T-22	Хувиргасан амьд организмыг ашиглах, экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх	Тусгай	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

23.	1-Э-23	Амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйлийг экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх	Энгийн	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
24.	1-Э-24	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх	Энгийн	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
25.	1-Э-25	Химийн хорт болон аюултай бодисын агуулахын үйл ажиллагаа эрхлэх	Энгийн	Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
26.	1-Э-26	Газрын доорх болон гадаргын усны эх үүсвэрийг аж ахуйн зориулалтаар ашиглах	Энгийн	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
27.	1-Э-27	Байгалийн жамаар унасан амьтны ясан эвэр, түүхий эдийн гарал үүслийн тодорхойлох	Энгийн	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
Хоёр. Санхүү, эдийн засгийн чиглэлээр				
28.	2-Т-01	Аудитын үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
29.	2-Т-02	Үнэт цаас үйлдвэрлэх	Тусгай	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
30.	2-Т-03	Гаалийн баталгаат агуулах эрхлэх	Тусгай	Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг төлөөлөх албан тушаалтан
31.	2-Т-04	Гаалийн баталгаат үйлдвэрийн газар байгуулах	Тусгай	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
32.	2-Т-05	Гаалийн баталгаат барилгын талбай байгуулах	Тусгай	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
33.	2-Т-06	Гаалийн тусгай бүс байгуулах	Тусгай	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
34.	2-Т-07	Гаалийн хяналтын бүс байгуулах	Тусгай	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан

35.	2-Т-08	Гаалийн зам эзэмших	Тусгай	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
36.	2-Т-09	Хөрөнгийн үнэлгээ хийх	Тусгай	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
37.	2-Т-10	Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
38.	2-Т-11	Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах	Тусгай	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
39.	2-Э-12	Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ эрхлэх	Энгийн	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
40.	2-Э-13	Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах	Энгийн	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
Гурав. Банк, банк бус санхүү, үнэт цаасны чиглэлээр				
41.	3-О-01	Банк байгуулах	Онцгой	Монгол банк
42.	3-О-02	Мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх	Онцгой	Монгол банк
43.	3-О-03	Мөнгөн тэмдэгт хэвлүүлэх	Онцгой	Монгол банк
44.	3-О-04	Алт цэвэршүүлэх	Онцгой	Монгол банк
45.	3-Т-05	Зээлийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Монгол банк
46.	3-Т-06	Төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Монгол банк
47.	3-Т-07	Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах	Тусгай	Монгол банк
48.	3-Т-08	Гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах	Тусгай	Монгол банк
49.	3-Т-09	Үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах	Тусгай	Монгол банк
50.	3-Т-10	Үнэт зүйл хадгалах	Тусгай	Монгол банк
51.	3-Т-11	Гадаад төлбөр тооцоо хийх	Тусгай	Монгол банк
52.	3-Т-12	Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах	Тусгай	Монгол банк
53.	3-Т-13	Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Монгол банк
54.	3-Т-14	Зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах	Тусгай	Монгол банк
55.	3-Т-15	Дотооддоо банкны нэгж байгуулах	Тусгай	Монгол банк
56.	3-Т-16	Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэцэд өөрчлөлт оруулах	Тусгай	Монгол банк

57.	3-T-17	Банкнаас хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах /хувьцааны хэмжээ, бүтэц өөрчлөгдснөөр шинээр хувьцаа эзэмшигч нэмэгдэх, аливаа этгээд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтэцэд өөрчлөлт оруулах/	Тусгай	Монгол банк
58.	3-T-18	Төлбөрийн карт гаргах, хүлээн авах үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Монгол банк
59.	3-T-19	Свитчийн үйл ажиллагаа эрхлэх буюу банк хоорондын картын гүйлгээний боловсруулалт хийх	Тусгай	Монгол банк
60.	3-T-20	Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Монгол банк
61.	3-T-21	Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх	Тусгай	Монгол банк
62.	3-T-22	Хууль тогтоомжоор хориглоогүй, Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх	Тусгай	Монгол банк
63.	3-T-23	Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
64.	3-T-24	Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
65.	3-T-25	Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
66.	3-T-26	Үнэт цаасны итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
67.	3-T-27	Үнэт цаасны андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
68.	3-T-28	Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
69.	3-T-29	Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
70.	3-T-30	Үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
71.	3-T-31	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
72.	3-T-32	Кастодианы үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
73.	3-T-33	Үнэт цаасны арилжааны үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
74.	3-T-34	Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
75.	3-T-35	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
76.	3-T-36	Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
77.	3-T-37	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
78.	3-T-38	Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо

79.	3-Т-39	Хөдөө аж ахуйн биржийн зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
80.	3-Т-40	Даатгалын үйл ажиллагаа эрхлэх /ердийн, урт хугацааны, давхар даатгалын/	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
81.	3-Т-41	Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
82.	3-Т-42	Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
83.	3-Т-43	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
84.	3-Т-44	Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
85.	3-Т-45	Банк бус санхүүгийн факторингийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
86.	3-Т-46	Банк бус санхүүгийн төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
87.	3-Т-47	Банк бус санхүүгийн төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
88.	3-Т-48	Банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
89.	3-Т-49	Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
90.	3-Т-50	Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
91.	3-Т-51	Банк бус санхүүгийн богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
92.	3-Т-52	Банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
93.	3-Т-53	Банк бус санхүүгийн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
94.	3-Т-54	Хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Санхүүгийн зохицуулах хороо
95.	3-Э-55	Шинжээчийн эрх олгох	Энгийн	Монгол банк

96.	3-Э-56	Банкны салбар, тооцооны төвд төлбөр тооцоо гүйцэтгэх зорилгоор код олгох	Энгийн	Монгол банк
97.	3-Э-57	Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ байгуулах	Энгийн	Монгол банк
98.	3-Э-58	Хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татах	Энгийн	Санхүүгийн зохицуулах хороо
99.	3-Э-59	Номинал дансаар дамжуулан харилцагчдад брокерын үйлчилгээ үзүүлэх	Энгийн	Санхүүгийн зохицуулах хороо
Дөрөв. Нийгмийн хэв журмын чиглэлээр				
100.	4-Т-01	Галт зэвсэг, сум импортлох, нийтэд худалдах	Онцгой	Засгийн газар
101.	4-Т-02	Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл худалдаалах төв ажиллуулах	Тусгай	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
102.	4-Т-03	Улсын хилээр нэвтрүүлэх байлдааны зориулалттай техник хэрэгсэл экспортлох, импортлох	Тусгай	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
103.	4-Т-04	Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл үйлдвэрлэх, дахин цэнэглэх	Тусгай	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
104.	4-Т-05	Галт, зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх /Тир ажиллуулах/	Тусгай	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
105.	4-Т-06	Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
106.	4-Т-07	Тамга тэмдэг үйлдвэрлэх	Тусгай	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
107.	4-Э-08	Тээврийн хэрэгсэл жолоодох	Энгийн	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
108.	4-Э-09	Хуульчийн үйл ажиллагаа эрхлэх	Энгийн	Хуульчдын холбоо
109.	4-Э-10	Нотариатын үйл ажиллагаа эрхлэх	Энгийн	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
Тав. Барилга, хот байгуулалтын чиглэлээр				
110.	5-Т-01	Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх олгох	Тусгай	Хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
111.	5-Т-02	Хот тосгоны газар зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллагын эрх олгох	Тусгай	Хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

112.	5-T-03	Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	Тусгай	Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
113.	5-T-04	Газрын кадастрын судалгаа хийх мэргэжлийн байгууллагын эрх олгох	Тусгай	Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
114.	5-T-05	Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн байгууллагын эрх олгох	Тусгай	Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
115.	5-T-06	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх, элэгдэл, эвдрэлд орсон газрын нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрх олгох	Тусгай	Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
116.	5-T-06	Өндөр элэгдэл, эвдрэлд орсон газрын нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрх олгох	Тусгай	Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
117.	5-T-07	Газрын кадастрын зураглал, бүртгэл, үнэлгээ хийх мэргэжлийн байгууллагын эрх олгох	Тусгай	Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
118.	5-T-08	Барилга байгууламж /бага, дунд, өндөр, онцгой төвөгшилтэй/-ийн зураг төсөл боловсруулах	Тусгай	Барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
119.	5-T-09	Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 16-аас дээш давхартай барилга, ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах	Тусгай	Барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
120.	5-T-10	Барилга байгууламж /бага, дунд, өндөр, онцгой төвөгшилтэй/-ийн барилгын ажил гүйцэтгэх	Тусгай	Барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
121.	5-T-11	Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 16-аас дээш давхартай барилга, ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх	Тусгай	Барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
122.	5-T-12	Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх	Тусгай	Барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
123.	5-T-13	Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх	Тусгай	Барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
124.	5-T-14	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах болон түүний ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх	Тусгай	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
125.	5-T-15	Барилга, байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох	Тусгай	Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
126.	5-Э-16	Барилга, байгууламжийг шинээр барих, барилгын өргөтгөл болон хийц бүтээц, цахилгааны эх үүсвэр, шугам сүлжээний зураг төсөлд хяналт хийх	Энгийн	Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан

127.	5-Э-17	Ус хангамж ариутгах татуургын төвлөрсөн системд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл олгох	Энгийн	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
128.	5-Э-18	Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн дүгнэлт гаргах	Энгийн	Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
Зургаа. Боловсрол, соёлын чиглэлээр				
129.	6-О-01	Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх	Онцгой	Засгийн газар
130.	6-Т-02	Түүх соёлын үнэт зүйл, түүх соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх	Тусгай	Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
131.	6-Т-03	Соёлын биет өвийг сэргээн засварлах үйл ажиллагаа эрхлэх	Тусгай	Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
132.	6-Т-04	Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх	Тусгай	Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
133.	6-Т-06	Нийтийн өмчийн соёлын биет өвийг хувилан олшруулах	Тусгай	Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
134.	6-Т-07	Цэцэрлэг байгуулах	Тусгай	Аймаг, нийслэлийн Засаг дарга
135.	6-Т-08	Гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэг байгуулах	Тусгай	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
136.	6-Т-09	Тусгай цэцэрлэг байгуулах	Тусгай	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
137.	6-Т-10	Ердийн ерөнхий боловсролын сургууль байгуулах	Тусгай	Аймаг, нийслэлийн Засаг дарга
138.	6-Т-11	Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль байгуулах	Тусгай	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
139.	6-Т-12	Ерөнхий боловсролын Тусгай сургууль байгуулах	Тусгай	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
140.	6-Т-13	Ерөнхий боловсролын лаборатори сургууль байгуулах	Тусгай	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
141.	6-Т-14	Их, дээд сургуулийн харьяа Ахлах сургууль байгуулах	Тусгай	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
142.	6-Т-15	Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хамтарсан сургууль байгуулах	Тусгай	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн



143.	6-Т-16	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах	Тусгай	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
144.	6-Т-17	Их сургууль, дээд сургууль, коллеж байгуулах	Тусгай	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
145.	6-Т-18	Шинэ хөтөлбөрөөр диплом, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх	Тусгай	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
146.	6-Т-19	Хүүхэд харах үйлчилгээ	Тусгай	Сум, дүүргийн Засаг дарга
147.	6-Э-05	Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын кино үйлдвэрлэгч кино зураг авалт хийх	Энгийн	Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
Долоо. Зам тээврийн чиглэлээр				
148.	7-О-01	Төмөр замын дэд бүтэц байгуулах эрх олгох	Онцгой	Засгийн газар
149.	7-О-02	Зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх	Онцгой	Засгийн газар
150.	7-О-03	Аюултай ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх	Онцгой	Засгийн газар
151.	7-Т-04	Авто-тээврийн хэрэгслийн улсын дугаар, тэмдэг үйлдвэрлэх	Тусгай	Зам, тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
152.	7-Т-05	Авто-тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, ажил эрхлэх	Тусгай	Зам, тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
153.	7-Т-06	Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх	Тусгай	Зам, тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
154.	7-Т-07	Аюултай ачаа тээвэрлэх	Тусгай	Зам, тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
155.	7-Т-08	Авто-тээврийн хэрэгсэл, түүний эд ангийн үйлдвэрлэл, дахин боловсруулах	Тусгай	Зам, тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрх олгосон албан тушаалтан
156.	7-Т-09	Усан замын тээврийн ажил үйлчилгээ эрхлэх	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
157.	7-Т-10	Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэх	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
158.	7-Т-11	Замын дээд ба доод бүтцийн барилга угсралтын ажил гүйцэтгэх	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

159.	7-T-12	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх - Төмөр замын дээд бүтэц үйлдвэрлэх /төмөр бетон дэр, зам төмөр, жижиг хэрэглэл, замын чигжээс/	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
160.	7-T-13	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх - Төмөр замын доод бүтэц үйлдвэрлэх /гүүр, ус зайлуулах хоолой, ул шороо/	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
161.	7-T-14	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх - Төмөр замын автоматик, телемеханик ба холбоо мэдээллийн байгууламжийн тоног төхөөрөмж үйлдвэрлэх	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
162.	7-T-15	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг угсрах үйл ажиллагаа эрхлэх - Төмөр замын доод бүтэц барих /далан, хоолой/	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
163.	7-T-16	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг угсрах үйл ажиллагаа эрхлэх - Дээд бүтэц угсрах	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
164.	7-T-17	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг угсрах үйл ажиллагаа эрхлэх - Төмөр бетон болон ган хийцтэй гүүр барих	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
165.	7-T-18	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг угсрах үйл ажиллагаа эрхлэх - Автоматик, телемеханик ба холбоо мэдээллийн байгууламжийн тоног төхөөрөмж угсрах	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
166.	7-T-19	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг угсрах үйл ажиллагаа эрхлэх - Галт тэрэгний хэвийн үйл ажиллагааг хангах эрчим хүчний байгууламж, тоног төхөөрөмж тохируулах, турших, угсрах	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
167.	7-T-20	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг засварлах үйл ажиллагаа эрхлэх - Дээд бүтэц засварлах	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
168.	7-T-21	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг засварлах үйл ажиллагаа эрхлэх - Доод бүтэц, хиймэл төхөөрөмж засварлах	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
169.	7-T-22	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг засварлах үйл ажиллагаа эрхлэх - Төмөр бетон болон ган төмөр гүүр засварлах	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
170.	7-T-23	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг засварлах үйл ажиллагаа эрхлэх - Автоматик, телемеханик ба холбоо мэдээллийн байгууламжийн тоног төхөөрөмж засварлах	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
171.	7-T-24	Төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн хэсгийг засварлах үйл ажиллагаа эрхлэх - Галт тэрэгний хэвийн үйл ажиллагааг хангах эрчим хүчний байгууламж, тоног төхөөрөмж засварлах, техникийн үзлэг, үйлчилгээ	Тусгай	Зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
